

**ХАРУУЛ ХАМГААЛАЛТ ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ, ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНД НЬ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гэрээт харуул хамгаалалт эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах, үйл ажиллагаанд нь хяналт тавих харилцааг зохицуулна.

1.2.Цагдаагийн байгууллага, алба хаагч гэрээт харуул, хамгаалалт эрхлэх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Цагдаагийн албаны тухай хууль, Гэрээт харуул, хамгаалалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

1.3.Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах албанаас тавих хяналт нь тухайн харуул, хамгаалалтын алба, бие хамгаалагчийн хамгаалалтын үйл ажиллагаанд хамаарах бөгөөд байгууллага, үйлчлүүлэгч, ажилтны бусад үйл ажиллагаа, хувийн нууцад халдахгүй.

Хоёр. Нэр томъёо

Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

“Харуул, хамгаалалтын байгууллага” – Харуул хамгаалалтын тухай хуулийн 3.1.5-д зааснаар;

“Хуулийн этгээд” - өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг.

“Харуул хамгаалалтын алба хаагч” - Харуул хамгаалалтын тухай хуулийн 3.1.4-д зааснаар.

Гурав. Гэрээт харуул, хамгаалалт эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх

3.1.Гэрээт харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангасан байна.

3.2.Гэрээт харуул, хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь цагдаагийн байгууллагад бүртгүүлэхдээ www.sas.police.gov.mn цахим хаягт байгууллагын холбогдох мэдээлэл (байгууллагын нэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, регистр, утасны дугаар, и-мейл хаяг)-ийг бүрэн оруулж, хүсэлт гаргана.

3.3.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын холбогдох албан тушаалтан нэгдсэн санд харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт илгээсэн хуулийн этгээдийн хүсэлтийг шалгаж нягтлаад зөв шаардлага хангасан тохиолдолд санд нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үгийг бүртгэлтэй и-мейл хаягаар илгээнэ.

3.4.Гэрээт харуул, хамгаалалтын нэгдсэн санд нэвтрэх нэр, нууц дугаар бүхий цахим шууданг хүлээн авснаар хуулийн этгээд байгууллагын дор дурдсан мэдээллийг санд оруулна:

3.4.1.байгууллагын мэдээлэл /байгууллагын нэр, өмчийн хэлбэр, улсын бүртгэл болон регистрийн дугаар, холбоо барих утас, и-мейл хаяг, байгууллагын хаяг, захирал албан тушаалтны дэлгэрэнгүй мэдээлэл, байгууллагын бусад мэдээлэл, өөрийгөө санхүүжүүлэх чадвартай эсэх талаарх холбогдох байгууллагын тодорхойлолт г.м/-ийг;

3.4.2.алба хаагчдын мэдээлэл /байгууллагын орон тоон дээр ажиллаж байгаа бүх алба хаагчдын ургийн овог, овог нэр, төрсөн огноо, регистрийн дугаар, албан тушаалын төрөл, мэргэжил, урьд ял шийтгэгдсэн эсэх талаарх мэдээлэл, холбоо барих утас, ажилд орсон он сар, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2011 оны 107/118 дугаар тушаалаар батлагдсан “Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчний дамжааны сургалтын хөтөлбөр”-т хамрагдсан талаарх мэдээлэл, хүн нэг тус бүрээр албаны дүрэмт хувцастай, зурагт г.м/-ийг;

3.4.2.тээврийн хэрэгслийн мэдээлэл /гэрээт харуул хамгаалалтын албанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жагсаалт, улсын дугаар, гэрчилгээний дугаар, тээврийн хэрэгслийн төрөл, марк, өнгө, загвар, зориулалт, тусгай зориулалтын дохио хэрэглэх зөвшөөрөл г.м/-ийг;

3.4.3.тусгай хэрэгслийн мэдээлэл /Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2003 оны 12/05 тоот тушаалаар батлагдсан харуул, хамгаалалтын алба хаагч галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл ашиглах зааврын дагуу хамгаалалтын үүрэг гүйцэтгэхэд хэрэглэгдэх гав, резинэн болон цахилгаан бороохой, гар станцны тоо ширхэг г.м/-ийг;

3.4.4.галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах мэдээлэл /харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдэд бүртгэлтэй галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн мэдээлэл/-ийг;

3.4.5.объектын бүртгэл мэдээлэл /гэрээгээр хамгаалах объектын нэр, төрөл, хаяг, талбайн хэмжээ,газар зүйн байршилд хамгаалалтын хэлбэр, хамгаалалтын үйл ажиллагааны чиглэл, гэрээ байгуулсан огноо, дугаар, дуусах хугацаа г.м/-ийг.

3.5.Цагдаагийн байгууллага гэрээт харуул, хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдийн нэгдсэн санд оруулсан мэдээллийг хянаж шаардлага хангасан тохиолдолд баталгаажуулж, хүсэлт гаргасан хуулийн этгээдэд цахимаар хариу өгнө.

3.6.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь энэ журмын 3.4-д заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдээс дор дурдсан баримт бичгийг хүлээн авна:

3.6.1.гэрээт харуул, хамгаалалт эрхлэхийг хүссэн өргөдөл;

3.6.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.6.3.радио давтамж ашиглах эрхийн бичиг, түүнийг нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.6.4.ажилчдын харьяа эрүүл мэндийн төвд (сэтгэц, бие бялдар) үзлэг хийлгэсэн эрүүл мэндийн тодорхойлолт;

3.6.5.ял шийтгэл эдэлж байсан эсэх талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт.

Дөрөв.Бүрдүүлсэн баримт бичгийг шалгах, гэрчилгээ олгох

4.1.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага гэрээт харуул хамгаалалт эрхлэх хүсэлт гарган, нэгдсэн санд мэдээллээ оруулсан хуулийн

этгээдийн мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор судалж, шаардлага хангасан тохиолдолд 1 жилийн хугацаатайгаар бүртгэлийн гэрчилгээ олгоно.

4.2.Хуулийн этгээд гэрээт харуул, хамгаалалтын нэгдсэн санд бүртгэгдэж, гэрчилгээ авснаар харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх эрх үүснэ.

4.3.Гэрээт харуул, хамгаалалтын тухай хуулийн 6.1 дэх хэсэг, энэ журмын 3.4, 3.6-д заасан материал бүрдүүлэлтийн шаардлага хангаагүй тохиолдолд хүсэлт гаргасан хуулийн этгээдэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзаж, албан бичгээр хариу өгнө.

Тав.Бүртгэлийн гэрчилгээг сунгах

5.1.Гэрээт, харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтээ нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад нэгдсэн санд бүртгэлтэй цахим хаягаар болон цаасаар гаргана.

5.2.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь мэдээллийг хянаж, бүртгэлийн гэрчилгээг 1 жилийн хугацаатайгаар сунгана.

5.3.Гэрээт харуул, хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд бүртгэлийн гэрчилгээг сунгуулахад дор дурдсан мэдээллийг гаргана:

5.3.1.цахимаар:

а/гэрээт харуул хамгаалалтын албаны бүтэн жилийн тайлан, шинээр ажилд орсон болон ажлаас халагдсан хүмүүсийн талаарх мэдээллийг санд нэмж оруулсан эсэх;

б/нэгдсэн санд оруулсан мэдээллээс шинэчлэгдсэн мэдээллийг нэмж оруулсан байдал;

в/өөрийгөө санхүүжүүлэх чадвартай эсэх талаарх холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт.

5.3.2.цаасаар:

а/тухайн гэрээт, харуул хамгаалалтын албаны үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсээс албан тодорхойлолт (Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллуулсан байдал, цагдаагийн байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажилласан байдал гэх мэт);

б/алба хаагчдыг албаны давтан сургалтад хамруулсан талаарх холбогдох материал.

Зургаа.Харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх

6.1.Дор дурдсан тохиолдолд харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлнэ:

а/цагдаагийн байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй;

б/хамгаалагчдын тоо шаардлага хангахгүй болсон.

6.2.Харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулах түдгэлзүүлэх шийдвэрийг үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгосон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага гаргана.

6.3.Түдгэлзүүлэх шийдвэр гарсан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн гэрээгээр хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэж, шийдвэрийн хэрэгжилтэд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хяналт тавина.

Долоо.Бүртгэлээс хасах

7.1.Дор дурдсан тохиолдолд харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгож, бүртгэлээс хасна:

а/цагдаагийн байгууллагад бүртгүүлснээс хойш нэг жилийн хугацаанд харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулаагүй;

б/харуул хамгаалалтын албаны удирдлага, ажилтнаас удаа дараа гэмт хэрэг, зөрчил гаргасан, зөрчлийг нуун дарагдуулсан, тухайн зөрчилд арга хэмжээ аваагүй;

в/бусдыг мөрдөн мөшгөсөн, хүн хуулийн этгээдийн талаар хууль бусаар баримт сэлт цуглуулсан;

г/харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах бүртгэлийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн;

д/хуулийн этгээд нь өөрөө хүсэлт гаргасан, татан буугдсан.

е/энэ журмын 3.4, 3.6-д заасан шаардлагыг хангахгүй болох нь тогтоогдсон.

7.2.Гэрчилгээг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар шийдвэр гарснаас хойш нэн даруй гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд, үйлчлүүлэгч байгууллага, харьяалах татварын албанд албан бичгээр мэдэгдэнэ.

Найм.Үйл ажиллагаанд нь хяналт тавих, хориглох зүйл

8.1.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагч, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаа, галт зэвсэг тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалалтад хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавина.

8.2.Цагдаагийн байгууллагаас холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран жил бүр гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил илэрсэн тохиолдолд энэ журамд заасны дагуу үйл ажиллагааг нь түдгэлзүүлж, зөрчлийг арилгуулах талаар мэдэгдэл өгч, хариу авна.

8.3.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах нэгжийн ахлах байцаагч гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сан бүрдүүлнэ.

8.4.Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хориглох зүйл:

8.4.1.зөвшөөрлийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, худалдах, барьцаанд тавихыг хориглоно;

8.4.2.төрийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах;

8.4.3.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд зааснаас бусад үйл ажиллагаа явуулах;

8.4.4.харуул хамгаалалтын алба хаагчид хууль тогтоомжид зааснаас өөр өнгө, загварын хувцас хэрэглүүлэх.

8.5.Гэрээт харуул хамгаалалтын бүртгэлийн гэрчилгээ олгосон, сунгасан тухай мэдээ, харуул хамгаалалтын албанд хийсэн хяналт, шалгалтын талаарх

мэдээллийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хагас, бүтэн жилээр гарган нэгтгэж, Нийтийн хэв журам хамгаалах албанд ирүүлнэ.

--- оОо ---